

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/017/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.24 № 389

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БИНДЭР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Засаг даргын харьяаны сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд холбогдох 1,473.8 мянган төгрөгийн, Засаг даргын Тамгын газарт холбогдох 10,264.3 мянган төгрөгийн, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-т холбогдох 46,109.3 мянган төгрөгийн нийт 4 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Төрийн захиргааны ажилтнуудад олгосон урамшууллаас 10,584.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, ашиглалтад орсон спорт заалны халаалтын төлбөрийг гүйцэтгэгч Бүтээлч шинэ сонголт ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй, 46,109.3 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг зөрчсөн байна.

232520

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд сумын татварын ба татварын бус орлогоос 999,036.1 мянга, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 1,405,194.8 мянга, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээс 378,854.9 мянга, төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас 48,950.7 мянган төгрөгийг бүрдүүлж, 2,490,608.6 мянган төгрөгийг зарцуулж, 132,724.4 мянган төгрөгийг сумын төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлжээ.

### **Аудитын гол асуудал**

Харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 352,638.7 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илрүүлснээс 302,390.8 мянган төгрөгийн 12 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 50,247.9 мянган төгрөгийн зөрчилд 2,384.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 47,863.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлжээ. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд алдаа, зөрчил илрээгүй.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны 12 дугаар сарын 18-ны хуралдааны 14 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 69 хувь, "Эрчимжүүлэх шаардлагатай" гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн төсөвт 647,624.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 351,411.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, биелэлт 154.3 хувь байна. Үүнд 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 205.6 хувиас 104 хувиар биелж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 100 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөр орлого 10.2 хувиар, торгуулийн орлого 52.8 хувиар, бусад орлого 95.3 хувиар буюу нийт 70,861.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар 531,505.0 мянган төгрөгийн 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс тодотголоор малын тоо толгойн татварын 55,000.0 мянган төгрөгийн орлогыг тэглэсэн боловч сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн батлаагүй, 437,208.7 мянган төгрөгөөр 13 арга хэмжээг хэрэгжүүлснээс 8 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 5 ажил бүрэн дуусаагүй, 89,537.0 мянган төгрөгийн 8 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Цаашид төсвийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,219,078.60</b>	<b>1,686,878.70</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	<b>368,048.50</b>	<b>701,318.20</b>
32	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	4а, 4б	<b>0</b>	<b>0</b>
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	<b>328,885.80</b>	<b>325,996.90</b>
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	<b>146,024.30</b>	<b>253,702.40</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	<b>376,120.00</b>	<b>405,861.20</b>
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	<b>0</b>	<b>0</b>
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	<b>0</b>	<b>0</b>
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>15,024,531.70</b>	<b>14,974,313.30</b>
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	11а, 11б	<b>0</b>	<b>0</b>
37100	Урт хугацаат хадгаламж		<b>0</b>	<b>0</b>
37200	Үнэт цаас		<b>0</b>	<b>0</b>
37300	Урт хугацаат зээл		<b>0</b>	<b>0</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	<b>15,024,531.70</b>	<b>14,974,313.30</b>
39100	Газар		<b>0</b>	<b>0</b>
39200	Биет хөрөнгө		<b>14,788,475.80</b>	<b>14,738,282.80</b>
39300	Биет бус хөрөнгө	13	<b>236,056.00</b>	<b>236,030.40</b>
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	<b>0</b>	<b>0</b>
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>16,243,610.30</b>	<b>16,661,192.00</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>28,184.60</b>	<b>314,394.60</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	<b>28,184.60</b>	<b>314,394.60</b>
41100	Богино хугацаат үнэт цаас		<b>0</b>	<b>0</b>
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	<b>0</b>	<b>0</b>
41300	Өглөг	17а, 17б	<b>28,184.60</b>	<b>23,926.50</b>
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	<b>0</b>	<b>290,468.10</b>
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>0</b>	<b>0</b>
42100	Урт хугацаат үнэт цаас	19	<b>0</b>	<b>0</b>
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	<b>0</b>	<b>0</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>16,215,425.80</b>	<b>16,346,797.40</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>16,215,425.80</b>	<b>16,346,797.40</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал		<b>714,443.50</b>	<b>714,443.50</b>
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		<b>217,635.90</b>	<b>217,635.90</b>
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		<b>0</b>	<b>0</b>
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		<b>0</b>	<b>0</b>
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		<b>0</b>	<b>0</b>
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		<b>0</b>	<b>0</b>
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		<b>0</b>	<b>0</b>
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		<b>15,008,891.70</b>	<b>15,140,263.40</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		<b>274,454.60</b>	<b>274,454.60</b>
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>16,243,610.30</b>	<b>16,661,192.00</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
------	---------------------	-----------	------------------------	------------------------

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		7,256,657.90	6,920,171.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		548,857.10	975,937.40
110	Орлогын албан татвар		367,337.20	777,956.20
1100	Хувь хүний орлогын албан татвар		367,337.20	777,956.20
113	Хөрөнгийн албан татвар		83,686.00	96,999.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж		97,833.90	100,981.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,847,387.40	1,764,942.00
120	Нийтлэг татварын бус орлого		3,847,387.40	1,764,942.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,860,413.50	4,179,291.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,325,938.10	6,433,224.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,325,938.10	6,433,224.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,678,284.90	4,027,050.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		573,561.70	906,675.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		73,974.20	111,592.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		44,579.90	627,751.40
2104	Хангамж, бараа материалын зардал		43,782.30	50,886.50
2105	Нормативт зардал		805.7	440
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,082.30	76,180.70
2107	Томилолт, зочны зардал		14,150.00	17,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,157,867.60	1,106,113.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		754,481.20	1,129,610.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,647,653.20	2,406,173.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,930,719.80	486,947.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		368,349.10	323,630.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,562,370.80	163,316.40

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		4,180,785.40	6,248,063.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО		548,857.10	975,937.40
110	Орлогын албан татвар		367,337.20	777,956.20
1100	Хувь хүний орлогын албан татвар		367,337.20	777,956.20
113	Хөрөнгийн албан татвар		83,686.00	96,999.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж		97,833.90	100,981.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		22,193.60	24,595.30
1181	Газрын төлбөр		6,562.20	8,100.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		69,078.10	68,285.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		766,430.90	1,083,376.50
120	Нийтлэг татварын бус орлого		766,430.90	1,083,376.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,865,497.40	4,188,749.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,656,232.20	5,365,484.70

21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,656,232.20	5,365,484.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,998,644.80	2,958,015.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		776,833.20	1,227,276.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		119,380.80	219,533.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		200,543.90	627,751.40
2104	Хангамж, бараа материалын зардал		306,497.10	626,059.50
2105	Нормативт зардал		823.7	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,461.80	99,634.00
2107	Томилолт, зочны зардал		14,225.00	17,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		485,988.60	82,809.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		77,890.80	57,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,657,587.40	2,407,469.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		524,553.20	882,579.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		429,183.50	549,309.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		429,183.50	549,309.40
2200	Дотоод эх үүсвэрээр		429,183.50	549,309.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-429,183.50	-549,309.40
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-139,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		139,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-43,630.30	333,269.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		411,678.80	368,048.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		368,048.50	701,318.20

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,570,596.40	0	13,570,596.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	77,331.40	0	77,331.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,647,927.70	0	13,647,927.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	5,127.20	0	5,127.20
8	Зарласан ногдол ашиг	0	0	0

9	Тайлант үеийн үр дүн	2,562,370.80	0	2,562,370.80
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,215,425.80	0	16,215,425.80
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,215,425.80	0	16,215,425.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,868.20	0	4,868.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,220,293.90	0	16,220,293.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	-36,813.00	0	-36,813.00
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	163,316.40	0	163,316.40
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	16,346,797.40	0	16,346,797.40

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,770,594.3</b>	<b>2,490,608.6</b>	<b>279,985.72</b>	<b>89.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,183,289.3</b>	<b>2,038,802.9</b>	<b>144,486.44</b>	<b>93.4</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,140,658.3</b>	<b>1,997,417.3</b>	<b>143,241.04</b>	<b>93.3</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>964,517.0</b>	<b>905,870.8</b>	<b>58,646.17</b>	<b>93.9</b>
210101	Үндсэн цалин	509,785.3	521,036.9	-11,251.59	102.2
210102	Нэмэгдэл	383,011.7	310,678.9	72,332.77	81.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,720.0	47,980.0	12,740.00	79.0
210104	Урамшуулал	11,000.0	25,975.0	-14,975.02	236.1
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	200.0	-200.00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>120,977.2</b>	<b>112,347.7</b>	<b>8,629.53</b>	<b>92.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	82,264.5	79,180.3	3,084.16	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	9,678.2	9,147.4	530.83	94.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,839.1	4,349.8	489.34	89.9
210204	Ажилгүйдлийн даатгал	4,839.1	3,698.0	1,141.05	76.4
210205	Эрүүл мэндийн даатгал	19,356.3	15,972.2	3,384.14	82.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>672,558.7</b>	<b>627,751.4</b>	<b>44,807.32</b>	<b>93.3</b>
210301	Гэрэл, цахилгаан	71,114.2	66,343.3	4,770.95	93.3
210302	Түлш, халаалт	589,334.5	554,987.2	34,347.33	94.2
210303	Цэвэр, бохир ус	12,110.0	6,421.0	5,689.04	53.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>54,027.1</b>	<b>46,110.9</b>	<b>7,916.23</b>	<b>85.3</b>
210401	Бичиг хэрэг	7,451.4	7,316.1	135.35	98.2
210402	Тээвэр, шатахуун	38,921.8	32,060.0	6,861.83	82.4

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,169.9	2,738.0	431.90	86.4
210404	Ном, хэвлэл	0.0	0.0	0.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	345.0	0.0	345.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,139.0	3,996.9	142.15	96.6
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>266.6</b>	<b>0.0</b>	<b>266.60</b>	<b>0.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.0	0.0	0.00	
210502	Хоол, хүнс	0.0	0.0	0.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	266.6	0.0	266.60	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>108,852.9</b>	<b>140,074.0</b>	<b>-31,221.08</b>	<b>128.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,509.3	60,206.7	-33,697.38	227.1
210602	Тавилга	0.0	0.0	0.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0	0.0	0.00	
210604	Урсгал засвар	82,343.6	79,867.3	2,476.30	97.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,620.5</b>	<b>17,800.0</b>	<b>2,820.50</b>	<b>86.3</b>
210701	Гадаад албан томилолт	0.0	0.0	0.00	
210702	Дотоод албан томилолт	20,620.5	17,800.0	2,820.50	86.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	0.0	0.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>78,114.6</b>	<b>69,798.1</b>	<b>8,316.53</b>	<b>89.4</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,674.2	66,754.9	5,919.29	91.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,210.3	581.0	629.30	48.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,132.4	900.0	232.40	79.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	644.1	305.2	338.85	47.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	279.5	0.0	279.50	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,196.7	1,054.0	142.70	88.1
210807	Газрын төлбөр	977.4	202.9	774.48	20.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>120,723.7</b>	<b>77,664.5</b>	<b>43,059.24</b>	<b>64.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,922.2	69,863.8	43,058.37	61.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,801.5	7,800.6	0.87	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,631.0</b>	<b>41,385.6</b>	<b>1,245.40</b>	<b>97.1</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>5,000.0</b>	<b>4,989.0</b>	<b>11.00</b>	<b>99.8</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,000.0	4,989.0	11.00	99.8
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.0	0.0	0.00	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>37,631.0</b>	<b>36,396.6</b>	<b>1,234.40</b>	<b>96.7</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,032.6	2,000.0	32.60	98.4

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	0.0	0.00	
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,647.9	7,647.9	0.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,324.0	23,848.7	475.30	98.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,626.5	2,900.0	726.50	80.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>505,005.0</b>	<b>451,805.7</b>	<b>53,199.29</b>	<b>89.5</b>
220001	Барилга байгууламж	0.0	0.0	0.00	
221001	Их засвар	0.0	0.0	0.00	
222001	Тоног төхөөрөмж	0.0	0.0	0.00	
223001	Бусад хөрөнгө	505,005.0	451,805.7	53,199.29	89.5
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>82,300.0</b>	<b>0.0</b>	<b>82,300.00</b>	<b>0.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	82,300.0	0.0	82,300.00	0.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,770,594.3</b>	<b>2,526,864.7</b>	<b>243,729.62</b>	<b>91.2</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	0.00	
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,566,844.2</b>	<b>2,477,914.0</b>	<b>88,930.24</b>	<b>96.5</b>
320001	Орон нутгийн төсвөөс	2,187,989.3	2,099,059.1	88,930.24	95.9
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	378,854.9	378,854.9	0.00	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>203,750.1</b>	<b>48,950.7</b>	<b>154,799.38</b>	<b>24.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,839.0	40,915.7	4,923.28	89.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,800.0	8,035.0	11,765.00	40.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	138,111.1	0.0	138,111.10	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	192,678.8		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	228,934.9		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>		
610001	Төсвийн байгууллага	3	3		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>33</b>	<b>33</b>		
620001	Удирдах ажилтан	10	10		
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13		
620003	Үйлчлэх ажилтан	6	6		
620004	Гэрээт ажилтан	4	4		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>33</b>	<b>33</b>		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10		

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15		
650010	Гэрээт ажилтан	0	0		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>40,192.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>40,192.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>38,329.1</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,487.1</b>
210101	Үндсэн цалин	1,778.3
210104	Урамшуулал	708.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,071.8</b>
210402	Тээвэр, шатахуун	1,021.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,050.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>600.0</b>
210604	Урсгал засвар	600.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,170.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,240.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	930.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,863.2</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,863.2</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	287.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,576.2
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>40,192.2</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>40,192.2</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,170.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,022.2

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Биндэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан, Биндэр ой анги ОНӨҮГ, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аймаг дахь Төрийн аудитын газар ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Платиниум прогресс аудит ХХК Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Стандарт дүгнэлт аудит ХХК Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв, Биндэр ой анги ОНӨҮГ, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ аудитын түүвэрт хамрагдсан болно.

### 3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 352,638.7 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илрүүлснээс 302,390,8 мянган төгрөгийн 12 алдаа<sup>1</sup>г санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 2,384.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 47,863.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **ЗДТГ:**

1. Санхүүгийн тайланд 42,629.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан. Үүнд:

- Залуу төгөл ХХК-д ойн менежментийн төлөвлөгөөний дагуу урьдчилгаанд 4,000.0 мянган төгрөгийг шилжүүлж зардалд бүртгэсэн
- Санхүүжилтийн орлогыг 14,158.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Тайлант оны элэгдлийн зардлыг нийт 1,508.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцож бүртгэсэн.
- Төсөвт төвлөрүүлсэн авлагын үлдэгдлийг 9,158.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд илүү илэрхийлж 8,746.2 мянган төгрөгийн материалын зардлыг хаасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд 5,058.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг тус тус залруулав.

2. Төрийн захиргааны албан хаагчид олгосон урамшуулал 9,110.6 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3. Цалингийн зардлаас 1,153.7 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 600.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсөнд төлж зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

#### **ИТХ:**

Төрийн захиргааны ажилтнуудад олгосон урамшууллаас 1,473.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### **Биндэр ой ОНӨҮГ:**

1. Санхүүгийн тайланд 219,148.1 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан. Үүнд:

- БОАЖЯ-аас үнэ төлбөргүй ирсэн 216,892.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг хандив, тусламжийн орлогоор бүртгэсэн.
- Санхүүгийн тайланд бараа материалын дансны үлдэгдлийг 118.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.
- Талбай тусгаарлалтын орлогын 1,237.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.
- Цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 900.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, өглөгөөр тусгаагүй алдааг тус тус залруулав.

#### **Биндэр нийтлэг ОНӨҮГ:**

1. Санхүүгийн тайланд 40,613.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Авто тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 36,812.9 мянган төгрөгийн зөрүүтэй тооцож тайлагнасан байна.
- Үндсэн түүхий эд материал дансанд 3,800.0 мянган төгрөгийн ямар бараа материал тодорхойгүй материалыг тайланд тусгасныг залруулсан.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

2. Ашиглалтад орсон спорт заалны халаалтын төлбөрийг гүйцэтгэгч Бүтээлч шинэ сонголт ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй 46,109.3 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгасан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 497.2 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илрүүлснээс 497.2 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,673.1 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 3,782.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **Соёлын төв:**

Санхүүгийн тайланд 497.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Жилийн эцэст сарын мэдээний программын сунгалтын үнэд 180.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлэн зардлаар бүртгэсэн.
- Төвлөрүүлсэн шилжүүлгийг 317.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулав.

#### **Ерөнхий боловсролын сургууль:**

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг 227.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

#### **Эрүүл мэндийн төв:**

1. Тайлант онд нэг ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 1,009.3 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Сахилгын шийтгэл оногдуулсан нэг ажилтанд сахилгын шийтгэл тооцсоноос хойш сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй байхад 1,435.9 мянган төгрөгийн урамшууллыг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Тайлант онд балансын урамшуулал даргад 1,471.0 мянган төгрөг, нягтлан бодогчид 1,471.0 мянган төгрөг, он дамжсан урамшуулал дүн бүртгэгчид 840.0 мянган төгрөг, нийт 3,782.0 мянган төгрөгийн урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, төсвийн жил дамнуулан олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### **3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье. илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	6	42,629.7			6	42,629.7	6	42,629.7				
Биндэр ой анги	4	219,148.1	2	2,138.1	2	217,010.0	4	219,148.1				
Биндэр нийтлэг үйлчилгээ	2	40,613.0			2	40,613.0	2	40,613.0				
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>12</b>	<b>302,390.8</b>	<b>2</b>	<b>2,138.1</b>	<b>10</b>	<b>300,252.7</b>	<b>12</b>	<b>302,390.8</b>				
Соёлын төв	2	497.2			2	497.2	2	497.2				
<b>УТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>497.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>497.2</b>	<b>2</b>	<b>497.2</b>				
<b>Дүн</b>	<b>14</b>	<b>302,888.0</b>	<b>2</b>	<b>2,138.1</b>	<b>12</b>	<b>300,749.9</b>	<b>14</b>	<b>302,888.0</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	2,664.8	1	911.1	1	1,753.7						
ИТХ	1	1,473.8	1	1,473.8								
Биндэр нийтлэг үйлчилгээ	1	46,109.3			1	46,109.3						
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>4</b>	<b>50247.9</b>	<b>2</b>	<b>2,384.9</b>	<b>2</b>	<b>47,863.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
ЭМТ	3	6,227.3	2	2,445.3	1	3,782.0						
ЕБС	1	227.8	1	227.8								
<b>УТБ-ын дүн</b>	<b>4</b>	<b>6455.1</b>	<b>3</b>	<b>2673.1</b>	<b>1</b>	<b>3,782.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
ТТЗ												
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>56,703.0</b>	<b>5</b>	<b>5,058.0</b>	<b>3</b>	<b>51,645.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>